



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2006 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 621

Улаанбаатар хот

Зарим хэрэгжүүлэгч агентлаг, харьяа
газруудын бүтэц орон тоог шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолын 5 дугаар заалт, 2006 оны 196 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэнтэй холбогдуулан Нийтийн тээвэр зохицуулалтын газрыг 2007 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс татан буулгаж Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Тээврийн газрыг 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулсугай.

Хоёр. Шинэчлэгдэн батлагдсан Боловсролын хуулийн дагуу нийслэлийн Боловсролын газар, дүүргүүдийн Боловсролын хэлтсийн үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон тоо, зохион байгуулалтын тухай санал боловсруулж 2007 оны 1 дүгээр сард багтаан батлуулахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Баатарзоригт даалгасугай.

Гурав. Өмчийн харилцааны газар, Тээврийн газар, Авто замын газрын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Батлагдсан бүтэц орон тоог чанд мөрдөж байгууллагынхаа дүрэм, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж ажиллахыг Өмчийн харилцааны газар, Авто замын газар, Тээврийн газрын удирдлагуудад үүрэг болгосугай.

Тав. Өмчийн харилцааны газар, Авто замын газар, Тээврийн газрын үйл ажиллагааг Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч Б.Баатарзориг, Улаанбаатар хотын ерөнхий менежер Г.Мөнхбаяр нарт даалгасугай.

Зургаа. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2005 оны 22 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 13, 15, хоёрдугаар хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР

0202319
МУХ.00.00.04



Нийслэлийн Засаг даргын 2006 оны
12-р сарын 27-ны өдрийн
621 дүгээр захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАРИМ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ХАРЬЯА ГАЗРУУДЫН БҮТЭЦ ОРОН ТООНЫ
ХЯЗГААР

д/д	Хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын нэр	Нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Өмчийн харилцааны газар	1.Өмчийн бодлого ашиглалт төлөөл- лийн хэлтэс 2.Өмчийн хяналт мониторингийн хэлтэс 3.Өмч хувьчлалын хэлтэс	28 үүнээс удирдлага 2
2	Авто замын газар	1.Захиргааны хэлтэс 2.Төлөвлөлт зураг төсвийн хэлтэс 3.Зам барилгын хэлтэс	35 үүнээс удирдлага 2
3	Тээврийн газар	1.Захиргаа санхүү, аж ахуйн хэлтэс 2.Тээвэр зохицуулалт, бүртгэл мэдээллийн хэлтэс 3.Хяналт шалгалтын хэлтэс	45 үүнээс удирдлага 2